

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Монголын Хуульчдын холбоо /цаашид “Хуульчдын холбоо” гэх/-ны дүрмийн 8.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид “Сургалтын хороо” гэх/-ны гишүүнд нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

Хоёр. Хороонд төлөөллөө оруулах эрх бүхий этгээд, төлөөлөгчийн тоо

2.1. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т “Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчдын холбооны хороодын төлөөллөөс болон хуульч профессоруудаас бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.”

2.2. Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Сургалтын хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос тус бүр хоёр, хуульч профессоруудаас долоон төлөөлөл оролцсон, нийт арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна.” гэж тус тус заасан.

Гурав.Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа

3.1.Сургалтын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг 2026 оны 04 дүгээр сарын 09-ны өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 17:30 цагийн хооронд явуулна.

3.2. Сургалтын хорооны гишүүнд нэр дэвших сонирхолтой хуульч өөрөө нэрээ дэвшүүлнэ.

3.3. Хуульчдын холбооны Шүүгч, Прокурор, Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөл, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их сургуулиудын захиргаа нь нэрээ дэвшүүлсэн хуульчдаас 3-аас доошгүй хуульчдыг тус тус сонгон холбогдох мэдээллийг Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлнэ.

3.4. Хуульчдын холбооны Зөвлөл нь Шүүгч, Прокурор, Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөл, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их сургуулиудын профессоруудаас сонгон ирүүлсэн хуульчдаас энэхүү удирдамжийн 2.1-д заасан төлөөллийг Сургалтын хорооны гишүүнээр сонгоно.

Дөрөв. Нэр дэвшигч хуульчид тавигдах шаардлага

4.1.Сургалтын хорооны гишүүнд нэр дэвших хуульч нь дараах шаардлагыг хангана:

- Сүүлийн 3 жилд хуульчийн мэргэжлийн хариуцлага, ёс зүйн зөрчил гаргаагүй байх;
- Хуульчийн нийтлэг үүргийн зөрчилгүй байх;
- Тухайн нэр дэвшүүлж буй хорооны гишүүн байх (хуульч профессорын төлөөлөлд энэ заалт хамаарахгүй)
- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;
- Эрх зүйн тодорхой салбараар 6-аас доошгүй жил мэргэшин ажилласан байх;
- Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

Тав. Бүрдүүлэх материал

5.1.Нэр дэвшигч нь дор дурдсан материалыг бүрдүүлж, Монголын Хуульчдын холбооны Тамгын газарт хүргүүлнэ. Үүнд:

- Төрийн албан хаагчийн анкет, 2 хувь цээж зураг (3x4);
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Мэргэжлээрээ ажилласныг нотлох баримт (ажлын газрын тодорхойлолт, эсвэл emongolia лавлагаа);
- Магистр эсхүл түүнээс дээш боловсролын зэргийн дипломын хуулбар;
- Магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд профессорын ажил эрхэлдгийг нотлох баримт буюу тодорхойлолт (шүүгч, прокурор, өмгөөлөгчийн төлөөлөлд энэ заалт хамаарахгүй).

Зургаа. Материал ирүүлэх хугацаа, хаяг

6.1.Хорооны гишүүнд нэр дэвшигчийн материалыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 17:30 цаг хүртэл Хуульчдын холбооны Тамгын газарт хүлээн авна.

Хаяг: Чингэлтэй дүүрэг 5-р хороо, Хуульчдын ордон 17 давхар, 1702 тоот.

Холбоо барих утас: 70116364 /3/

-oOo-